



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар A/166

Улаанбаатар хот

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12, 2025 оны "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл" батлах тухай 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу, томуу төст өвчний тархалт, улаанбурхан өвчний дэгдэлт нэмэгдэж, эмнэлгийн ачаалал буурахгүй байгаатай холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн хүсэлтийг үндэслэн хүүхдийн нэмэлт тасгуудад техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах төсвийг хавсралтаар баталж, зарцуулагдах 19,000,000 (Арван есөн сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль", журамд нийцүүлэн тоног, төхөөрөмж худалдан авч, тайлагнахыг Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэг (Ц.Олонбаяр)-т, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Хосбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТӨР

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
А/АСС дугаар захирамжийн хавсралт

ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

6020100755
9001904-3-CBT23271

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт тоо ширхэг	Нийт үнэ
СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ					
1	Өвчтөний ор	ширхэг	950,000	20	19,000,000
БҮГД ДҮН					19,000,000